Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Угтаалцайдам сумын Засаг дарга нь Төв аймгийн Засаг даргатай байгуулсан “батламж” гэрээндээ 8 чиглэлийн 31 арга хэмжээг төлөвлөж, 95.7 хувиар хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Угтаалцайдам сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/74 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгж байгуулсан. Энэ нэгж 10 ажил төлөвлөж төсөвт байгууллагуудын хоол хүнс, үдийн цайны хэрэгжилт болон эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа, хөтөлбөр төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг хийгддэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу санхүүгийн хяналт шалгалт явуулж, дотоод аудитын чиг үүргийг гүйцэтгэдэг.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын эх сурвалжийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг, суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл БАГА гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 3,625,140.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 72,502.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 58,002.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 3,860,112.6 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 77,202.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 4,699.4 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 61,761.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем програмыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 1,527,000.5 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 748,457.1 мянган төгрөгийн санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалаас 17,309.6 мянган төгрөгийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангийн 45,406.9 мянган төгрөгийн санхүүжилт, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 73,392.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 3,094.0 мянган төгрөг, нийт 2,414,660.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Угтаалцайдам сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 47,860.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 21,947.4 мянган төгрөг, нийт 69,807.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тогтоолд татварын болон татварын бус орлогын ангиллыг газрын төлбөрийн 17,047.4 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын 163,045.7 мянган төгрөг, татварын бус орлого 9,713.0 мянган төгрөг, нийт 172,758.7 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 102,951.3 мянган төгрөгөөр буюу 2.4 дахин давуулж биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд малын тоо толгойн албан татвар шинээр бий болсон, зөрчлийн хуулийн дагуу торгуулийн орлого нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 45,964.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 331,990.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор, нийт 377,954.6 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба тайлант онд 384,231.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж хассан, ЗДТГ-аас ЭМТ-д балансаас балансад 1,500.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 336,422.6 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 183,635.8 мянган төгрөгийн, нийт 520,058.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 507,550.9 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 71,992.8 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 193,639.4 мянган төгрөг, ажиллагсадтай холбоотой авлага 392.1 мянган төгрөг, нийт 266,024.2 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 188,722.1 мянган төгрөг буюу 70.9 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Ажилчидтай холбогдсон өглөг 76.0 мянган төгрөг, байгууллагад төлөх 20,827.9 мянган төгрөг, нийт 20,903.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 514,714.1 мянган төгрөг, арилжааны банк дахь эргэлтийн эмийн сангийн харилцах дансанд 3,977.2 мянган төгрөг, нийт 518,691.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 258,858.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 6,019,510.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	226,847.8	518,691.3	291,843.5
Авлага	289,931.7	266,024.2	-23,907.5
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	246,350.6	258,858.1	12,507.5
Үндсэн хөрөнгө	5,975,925.2	6,019,510.8	43,585.6
Нийт хөрөнгө	6,739,055.3	7,063,084.5	324,029.1
Өр төлбөр	7,251.6	20,903.9	13,652.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,731,803.7	7,042,180.5	310,376.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,739,055.3	7,063,084.5	324,029.1

Бараа материалын дансны үлдэгдэл 258,858.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 12,507.5 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,019,510.8 мянган төгрөг болж 43,585.6 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламжийн дансанд аймгийн хөрөнгө оруулалтаар ЕБС-д 49,818.2 мянган төгрөгийн барилгын дээврийн засвар, ЗДТГ-т 21,650.0 мянган төгрөгийн 2 худаг орлого авсан нь шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,042,180.5 мянган төгрөг болж 310.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 2,808,110.0 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна

2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолоор нийт 2,608,118.0 мянган төгрөгөөр буюу төсвийн төслөөс 199,992.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолоор төсөв 2,728,336.0 мянган төгрөг болж 123,192.6 мянган төгрөгөөр нэмэгдэж тодотгол хийгдсэн.

Угтаалцайдам сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 47,860.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 21,947.4 мянган төгрөг, нийт 69,807.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тогтоолд татварын болон татварын бус орлогын ангиллыг газрын төлбөрийн 17,047.4 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Угтаалцайдам сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 07 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 1,527,000.5 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 748,457.1 мянган төгрөгийн санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалаас 17,309.6 мянган төгрөгийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангийн 45,406.9 мянган төгрөгийн санхүүжилт, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 73,392.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 3,094.0 мянган төгрөг, нийт 2,414,660.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын 163,045.7 мянган төгрөг, татварын бус орлого 9,713.0 мянган төгрөг, нийт 172,758.7 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 102,951.3 мянган төгрөгөөр буюу 2.4 дахин давуулж биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд малын тоо толгойн албан татвар шинээр бий болсон, зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн орлого нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Гүйцэтгэлээр 2,258,189.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 26,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 200.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,284,389.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 130,271.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,284,389.2 мянган төгрөг буюу 83.7 хувьтай хэрэгжсэн байна

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолоор төсөвт урьд оны шилжих үлдэгдлээс тодотгол хийж соёлын төвийн барилгын дээврийн засварт 50,000.0 мянган төгрөг, ковид-19 цар тахлын зардалд 30,000.0 мянган төгрөг, орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан тушаалтны тэтгэмжийн зардалд 6,313.2 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад 12,907.4 мянган төгрөг, нийт 109,220.6 мянган төгрөгийг нэмж баталснаас тэтгэмжийн зардалд 6,313.2 мянган төгрөг, ковид-19 цар тахлын зардалд 10,165.0 мянган төгрөг, цахим худаг гаргахад 8,800.0 мянган төгрөг, компьютер техник хэрэгсэл худалдан авахад 15,200.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 262,637.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 160,359.3 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 102,278.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Угтаалцайдам сумын дотоод хяналтын нэгжээс сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хугацаа хэтэрсэн 25 зээлдэгчийн зээлийг шүүхэд өгч шийдвэрлүүлэхээр санхүү албаны даргад үүрэг даалгавар өгөгдсөн байна.

Угтаалцайдам сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ийн санхүүгийн тайланд 21,650.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,760.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 1,982.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дундманхайдай аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргаж, эмийн эргэлтийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд үнийн дүнгүй 1 албан шаардлага, 590,3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 53,641.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1,219.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 1 албан шаардлага, 310.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,444.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж, эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланд 21,239.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитыг гүйцэтгэсэн	Шалгагдагч байгууллага	Албан шаардлага		Төлбөрийн акт		Зөвлөмж		Нийт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
ТАБ	ЗДТГ	1	21,650.0	3	2,760.5	1	1,982.1	5	26,392.6
	ИТХ							0	-
	СТөв					1	314.9	1	314.9
	СХСан	1	166,543.8			1	7,218.8	2	173,762.6
	БНСБСан							0	-
	Дүн-1	2	188,193.8	3	2,760.5	3	9,515.9	8	200,470.1
ХАК	ЕБС	1	-	2	590.3	3	53,641.1	6	54,231.3
	СӨБ					2	1,219.6	2	1,219.6
	ЭМТ	1	-	1	310.1	1	1,444.9	3	1,755.1
	ЭЭС					3	21,239.6	3	21,239.6
		Дүн-2	2	-	3	900.4	9	77,545.2	14
	Нийт дүн	4	188,193.8	6	3,660.9	12	87,061.1	22	278,915.7

3.8 Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд баригдах цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 23,647.6 мянган төгрөгөөр бэлчээрийн 2 худаг, сургуулийн дээврийг 49,818.3 мянган төгрөгөөр, сумын шилжих үлдэгдлээс 8,800.0 мянган төгрөгөөр 1 цахим худаг санхүүжүүлсэн байна.

Дотоод хяналтын нэгж нь 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/74 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Нийт 10 ажил төлөвлөж төсөвт байгууллагуудын хоол хүнс, үдийн цайны хэрэгжилт болон эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа, хөтөлбөр төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. Гэвч өмнөх оны аудитаар өгөгдсөн шилэн данс, татварыг нэр төрлөөр нь биелүүлэх, харьяа байгууллагуудын татварын тодорхойлолтыг үнэн зөв тохируулах зэрэгт дотоод хяналтыг чиглүүлж ажиллаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ТТЗ-ийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 11 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл байна. Хэрэгжилт 97.1 хувьтай байна. Аудитын явцад ТТЗ-ийн нэрийг залруулсан.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/241 дугаар албан бичгээр ирүүлсэн ба шилэн дансны мэдээллийг үнэн зөв байршуулах гэсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд газар эзэмших, ашиглах эрх шилжилтийн бүртгэлийн судалгааг газрын даамлаас авч татварыг бүрэн авсан эсэхийг тулган шалгахад дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Угтаалцайдам сумын Засаг даргын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17,047.4 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан Угтаалцайдам сумын ИТХ-ын тайланд 1,516.0 мянган төгрөгийн 1 залруулга, соёлын төвийн тайланд 92.5 мянган төгрөгийн 1 залруулга хийгдэж, сум хөгжүүлэх сангийн 166,543.8 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 7,218.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, соёлын төвийн 314.9 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, эргэлтийн эмийн сангийн 21,239.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан байна.

4.1 Залруулсан алдаа

Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, энэ тайланд нэгтгэгдсэн түүвэрт хамрагдсан дараах 2 байгууллагын санхүүгийн тайлангийн алдаанд залруулга хийгдсэн байна. Үүнд:

Сумын ИТХ-ын төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 1,515.9 мянган төгрөгөөр тохируулаагүй, зөрүүтэй тайлагнасан алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Соёлын төвийн төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 92.5 мянган төгрөгөөр тохируулаагүй, зөрүүтэй тайлагнасан алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан болон тайланд нэгтгэгдсэн түүвэрт хамрагдсан байгууллагуудад төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

4.3 Албан шаардлага

Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайланд албан шаардлага хүргэгдээгүй, энэ тайланд нэгтгэгдсэн түүвэрт хамрагдсан сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн 1 зөрчилд албан шаардлага хүргэгдсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 166,543.8 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй зээл байгаа зөрчил байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа,

зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Угтаалцайдам сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайланд 3 зөвлөмж, түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн 5 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 47,860.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 21,947.4 мянган төгрөг, нийт 69,807.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тогтоолд татварын болон татварын бус орлогын ангиллыг газрын төлбөрийн 17,047.4 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогын дансны хуулгыг үнэн зөв боловсруулж, татварын болон татварын бус орлогыг мэдээлэх, нэр төрлийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах

2. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төсөвт байгууллагуудын татварын өр, авлагын тодорхойлолтыг etax.mta.mn системээр гаргахад төсвийн нийт 6 байгууллагад 6,780.9 мянган төгрөг дутуу, 105,931.9 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй гэж тайлагнасан нь ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын тодорхойлолтын үлдэгдэл санхүүгийн тайлангийн өр, авлагын үлдэгдэлтэй тохирдог байх.

3. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

ТТЗ-ийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 11 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл, хэрэгжилт 97.1 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмуудыг хангуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах

4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүй төсвөөс 2021 оны 6 дугаар сарын 15-нд 314.9 мянган төгрөгийн музейн үзмэр худалдан авсан зөрчил байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх.

5. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 7,218.8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

6. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг 2 оноор зэрэгцүүлж тайлагнаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалт, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" журмын 2.1.8-д "Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад төсвийн байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэхүйц" байх зарчим болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эргэлтийн эмийн сангийн тайлангийн мэдээллүүдийг зэрэгцүүлсэн байдлаар тайлагнах

7. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланд тайлагнасан 810.3 мянган төгрөгийн авлага, 3,846.1 мянган төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өр, авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулж байх.

8. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

8.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сангийн тайлант хугацааны борлуулалтын орлогыг цахим баримттай тулган шалгахад 20,429.2 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг анхан шатны албан ёсны баримтаар баталгаажуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эргэлтийн эмийн сангийн борлуулалтын орлогыг албан ёсны анхан шатны цахим баримтаар баталгаажуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Угтаалцайдам Засаг дарга	3	17,047.4		-				0	3	17047.4
2	Угтаалцайдам ИТХ	1	1,516.0	1	1,516.0				0		0
3	Угтаалцайдам Соёлын төв	2	407.4	1	92.5				0	1	314.9
4	Угтаалцайдам СХСан	2	173,762.6		-			1	166,543.8	1	7,218.8
5	Угтаалцайдам ЭЭСан	3	21,239.6		-				-	3	21,239.6
	Нийт дүн	11	213,972.6	2	1,608.5	-	-	1	166,543.8	8	45,820.7

